



**НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2014 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/СД

Улаанбаатар хот

**Аэробик гимнастикийн тэмцээн
зохион байгуулах тухай**

Монгол Улсын "Биеийн тамир, спортын тухай" хууль, Засгийн газрын 2009 оны 05 дугаар тогтоол, 2014 оны 34 дүгээр тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийн 2014 оны зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын аварга шалгаруулах Аэробик гимнастикийн тэмцээнийг 2014 оны 11 дүгээр сарын 01-02-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулсугай.
2. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 4.960.000 /дөрвөн сая есөн зуун жаран мянга/ төгрөгийг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын уралдаан тэмцээний төсвөөс гаргахыг нягтлан бодогч О.Эрдэнэцэцэгт зөвшөөрсүгэй.
4. Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг ахлах мэргэжилтэн А.Болдмаад үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

1150500141